



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



JAPAN INTERNATIONAL
COOPERATION AGENCY

**Улаанбаатар хот дахь ХБИ-ийн
нийгмийн оролцоог дэмжих
төсөл (DPUB)**

Мэдээллийн эмхэтгэл №17

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160,
Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн
газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас:

[https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас:

[https:// www.jica.go.jp/project/ mon-golia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mon-golia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com

**JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE
дарж нэгдээрэй!!**

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **2580** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.



NHK World, Зураг авалтын “Хөшигний ард”



Зураг авалтын үеэр

Та бүхэн 7-р сарын 11-ний өдөр цацагдсан “SIDE BY SIDE” нэвтрүүлгийг үзсэн үү? Төслийн үйл ажиллагааны талаарх тус нэвтрүүлгийн зураг авалт 4-р сарын 17-оос эхэлж 9 хоногийн турш үргэлжилсэн. Яг тухайн үед Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулагдаж байсан. Нэвтрүүлэг гарсны дараах Тэрүя мэргэжилтний сэтгэгдлийг та бүхэнтэй хуваалцаж байгаадаа таатай байна.

Тухайн үед 2 долоо хоногийн сургалтыг ганцаараа хариуцаж байсан учраас зураг авалтын үеэр ямар ч завгүй найруулагч болон зураглаачыг хажууд байсан ч анзаарах сөхөөгүй байлаа. Тийм учраас миний зургийг авах үед ямар ч бэлтгэлгүй, яг л байгаагаараа гарсан ... Одоо бодоход хэлэх үгээ цэгнэж, хувцаслалт, нүүр царайндаа илүү их анхаарал хандуулах хэрэгтэй байж ээ хэмээн бага зэрэг харамсаж байна. Бууз хийсэн хэсгийн зургийг Бямба гарагт авсан юм. Тэр үед ажлын ачааллаас болж ядраад, хүзүүн дээр хатиг гарсныг эмнэлэгт очиж хагалуулсан байсан. Тийм учраас хүзүүнийхээ баруун талд гарын алганы хэмжээтэй том лент наасан байсан боловч аргагүй л мэргэжлийн хүмүүс юу ч мэдэгдүүлэлгүйгээр гаргасан байсан. Харин бууз гаргах үед уур савсаж буй хэсгийн зургийг авахын тулд би хэд хэдэн удаа жигнүүрийн тагийг авч үзүүлэх хэрэг гарсан юм. Мөн энэ удаагийн нэвтрүүлгээр төслийн танилцуулга, ялангуяа Монгол дахь DET Сургагч багш нарын үйл ажиллагааг онцолсонд их баяртай байна. Нэг харамсалтай зүйл нь 2 жилийн хугацаанд нэвтрүүлгийн бэлтгэл ажлыг хийж ирсэн ахлах зөвлөх Чича бараг гараагүйТус нэвтрүүлгийг 7-р сарын 25-ны өдрийг хүртэл доорх линкээр орж үзэх боломжтой. Харахан үзэж амжаагүй байгаа хүмүүс заавал сонирхон үзээрэй.

<https://www3.nhk.or.jp/nhkworld/en/tv/sidebyside/20180711/2037044/>

Налайх дүүрэгт DET + Туслах аргачлалын талаарх сургалт зохион байгууллаа. (2018.07.16)



Оролцогчид хөгжлийн бэрхшээлийн талаар харилцан ярилцаж байна.

Налайх дүүрэг “Хүн бүрт ээлтэй дүүрэг” болох зорилт тавин ажиллаж байна. Энэ утгаараа хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэмжийг гэрт нь очиж олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн гэрт нь очиж хичээл заах гэх мэт гэрээр үйлчилгээ үзүүлэх ажлуудыг нэвтрүүлж байгаа юм. Дүүргийн орлогч дарга Баттулга төслийн оффист хүрэлцэн ирж “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэрээсээ гарч, нийгэмд оролцох боломжтой орчинг бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байна.” хэмээн төслийн мэргэжилтнүүдтэй уулзалт хийснээр энэ удаагийн сургалтыг зохион байгуулахаар болсон. Улмаар 6-р сарын 19,22-ны 2 өдөр бүтэн өдрийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд Халамжийн үйлчилгээний хэлтэс, Цагдаагийн байгууллага, Сургууль, Банкны

ажилтан гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй өдөр тутам харьцдаг салбар салбарын 60 орчим хүн оролцлоо. “Юуны өмнө оролцогчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг өөрчлөх хэрэгтэй” гэдэг утгаар үдээс өмнө нь Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET), үдээс хойш нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаар практик сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр “Тухайн хүнээс өөрөөс нь асуух нь чухал” гэдэг санааг оролцогчдод хүргэж байв. “Гэнэт гарнаас нь татах, тэргэнцэрийг нь зөвшөөрөлгүйгээр түрэх” зэрэг муу жишээнүүдийг танилцуулж, оролцогчид өөрсдөө практик дасгал ажил ч гэсэн хийсэн. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт+Үйлчилгээ үзүүлэх, туслах аргачлал гэсэн цогц сургалтанд хамрагдсанаар оролцогчдын ойлголт, хандлага өөрчлөгдсөн гэдэгт итгэлтэй байна.

Тус төслийн мэргэжилтэн Тэрүягийн тухай нэвтрүүлэг MNB телевизээр гарлаа.

- Өдөр,цаг : 7/8 (Ням) 19 : 00-19 : 25
- Нэвтрүүлгийн нэр : Миний тэмдэглэлүүд
- Агуулга : Төслийн үйл ажиллагаа, Тэрүя мэргэжилтний хариуцаж буй ажил, DET сургагч багш нарын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлийн ойлголт, ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийг зорьж буй Тэрүя мэргэжилтний тухай.



Нэвтрүүлгийн хэсгээс...

4 дэх удаагийн JCC хурал зохион байгуулагдлаа. (2018.07.10)



JCC хурлын гишүүд

DPUB төслийн үйл ажиллагаа эхлээд 2 жил өнгөрч байгаа ба энэ удаа 4 дэх удаагийн JCC (Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал) зохион байгуулагдлаа. Төслийн нийт хэрэгжих хугацаа яг талдаа ороод байгаа бөгөөд үлдсэн 2 жилийн хугацаанд үр дүнтэй, амжилттай үйл ажиллагаа явуулахад шаардлагатай олон асуудлыг хэлэлцлээ. Хурлын эхэнд 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулж, дараа нь сүүлийн хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Энэ жил Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчлэн батлах, Мэдээллийн хүртээмжийн семинар гэх мэт чухал ажлууд үргэлжлэн явагдана. Төслийн зүгээс ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд багахан ч гэсэн хувь нэмэр оруулах ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ. Та бүхнийг цаашид ч гэсэн DPUB төслийг дэмжин ажиллахыг хүсэж байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг-Нийгмийн комисс (ESCAP)

НҮБ-д дадлага хийхээр мэдээлэл хайж байх үед ESCAP гэж огт мэддэггүй байлаа. UNICEF болон UNESCO, UNDP-н талаар сонсож байсан учраас эхлээд эдгээр байгууллагуудад өргөдлөө өгье гэж бодож байсан боловч “нийгмийн хөгжил” гэсэн түлхүүр үгээр хайлт хийж үзэхэд ESCAP гэж гарч ирсэн. Ингээд тухайн үед Нийгмийн хөгжлийн хэлтэст дадлага хийж, үүний үр дүнд мэргэжилтэн болоод буцаад очих үед үнэхээр баяртай байлаа. НҮБ-д ажиллах мөрөөдөлтэйгээр 1996 оны 9-р сард ажлаасаа гарсан бол ESCAP-д 2001 оны 1-р сард ажилд орсон юм. Эхний өдөр ажилдаа очиход танил дотно албан хаагчид намайг утгаж авсан нь их сайхан санагдсан. Мөн НҮБ-д мэргэжилтэн бүр өөр өөрийн өрөөтэй тул ажлын байрны орчин нь ч тохилог байв. Ингээд би ноён Такаминэ Ютакагийн туслахаар ажиллаж эхэлсэн. Улмаар цахим хуудсаар дамжуулж хөгжлийн бэрхшээлийн талаар мэдээлэл цуглуулах, түгээх, мөн цахим хуудасны хүртээмжтэй байдлыг хангах үүрэгтэйгээр ажиллаж байв. Үнэнийг хэлэхэд тухайн үед хөгжлийн бэрхшээлийн салбарын талаарх мэдлэг муутай байсан бөгөөд Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар, ХБИ-ийн хөдөлгөөн, Хөгжлийн бэрхшээлийн бодлого гэх мэтийн талаар ямар ч ойлголтгүй байсан. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцох боломжтой нийгмийн орчинг бүрдүүлнэ гэсэн ажлынхаа учир утгыг бол ойлгож байсан. (Үргэлжлэл бий...)

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт: Олон улсын чиг хандлага” Онол практикийн хурал зохион байгуулагдлаа. (2018.07.16)

ХБИ-ийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд хөгжлийн бэрхшээлийн асуудалд хандах зөв ойлголт чухал байдаг. Тийм учраас хөгжингүй орнуудад Хөгжлийн бэрхшээл судлал



Хурлын үеэр

гэх шинжлэх ухаан хөгжиж, нийгэм рүү чиглэсэн төрөл бүрийн нөлөөллийн ажлуудыг явуулж байна. Монгол Улсад одоохондоо шинжлэх ухаан болж хөгжөөгүй байгаа боловч хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгааны ажлууд хийгдэж байна. Энэ удаа DPUB төслийн үйл ажиллагааны хүрээнд Хөгжлийн бэрхшээлийн эрдэм шинжилгээний хурлыг Монгол-Япон төвд зохион байгууллаа. Тус хуралд 60 гаруй хүн оролцсон бөгөөд ХНХЯ, БСШУЯ, Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, Барилгын хөгжлийн төв зэрэг байгууллагууд



Ахлах зөвлөх Чива Хисао